

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогын удирдлага, зохицуулалт, тайлагналт, шим тэжээлийн асуудал хариуцсан шинжээч,
Даваасүрэн Цэндсүрэн

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах							
1	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийж, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.	Хуулийн төсөл	Хуулийн үзэл баримтлалын төсөл	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хүнсний хангамжид хамаарах хэсгийн хэрэгжилтэд ХХААХҮЯ-наас үнэлгээ хийсэн. Үнэлгээний дүн, саналд үндэслэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлал боловсруулах суурь судалгааг хийсэн. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 1а/1392 дугаартай албан бичгээр ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. Уг хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлалыг Хүнс, хөдөө аж ахуй,хөнгөн үйлдвэрийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран батална. Үзэл баримтлал нь төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага, хамрах хүрээ, зохицуулалт, үр дагавар гэсэн бүтэцтэй бөгөөд дор дурдсан харилцааг зохицуулахаар тусгасан. Үүнд: 1. Хуулийг Боловсролын ерөнхий хуультай нийцүүлэх, холбогдох төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нэмж тусгах; 2. Хүнсний хангамжийн хүртээмж, тогтвортой байдлыг хангах, хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, түүнд төр, хувийн хэвшил, орон нутгийн оролцоог	
--	--	--	--	--	--	--

					уялдуулан хангах, орон нутгийн эрх үүргийг нэмэгдүүлэх. Хүнсний хангамжийг төр, хувийн хэвшилтэй хамтран орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулах замаар тухайн орон нутгийн компани, нөхөрлөл, хоршоодын оролцоог хангаж, чанар аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хүртээмжтэй, тасралтгүй, тогтвортой үнээр ханган нийлүүлэлтийн нэгдсэн төвийг байгуулах. Хүнсний хангамжийг орон нутгийн онцлогт тохирсон байдлаар хэрэгжүүлэх; 3. Санхүүгийн олон талт эх үүсвэрийг бий болгох, бэхжүүлэх; 4. Хоолны зардлыг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх; 5. Салбар хоорондын уялдааг зохицуулах тогтолцоог бий болгох, үдийн хоолны хөтөлбөрийг хянах, үнэлэх тогтолцоог бий болгох зэрэг асуудлыг тусгасан. Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	---	--	--

2	Сургуулийн үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна.	хоол	Төлөвлөгөө, Засгийн газрын тогтоолын төсөл	Засгийн газрын 2020 оны 207, 2021 оны 18 дугаар тогтоол	Холбогдох тооцоо судалгаа хийж, аймаг, орон нутаг, нийслэлийн түвшинд хүнсний хангамж, хоол шим тжээлийн боловсролын бодлогын шийдэл хувилбар боловсруулан дунд хугацааны төлөвлөгөөний төсөл боловсруулна.	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын техникийн дэмжлэгтэйгээр Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх бодлогын шийдэл боловсруулах зөвлөх үйлчилгээний хүрээнд сургуулийн суурь судалгааг шинэчлэн боловсруулах, хоолны зардал дахь хүнсний бүтээгдэхүүний эзлэх хэмжээг тодорхойлох, хоол хүнсний хангамжийг бүс, аймаг, сумын түвшинд зохион байгуулах хувилбарт шийдэл, хүний нөөц, хоол үйлдвэрлэлийн байрын төлөвлөлт, санхүүжилтийн олон талт хувилбарын шийдэл боловсруулах бодлогын судалгааг хамтран хийж байна. Уг судалгаанд үндэслэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
---	--	------	--	---	---	---	--	---

1.2. Сургуулийн өмнөх, ерөнхий болон тэгш хамран сургах боловсролын хөгжлийн чиглэлээр батлагдсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн удирдлага, зохицуулалтыг хангах чиглэлээр дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах

3	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоолны зардлын нормативыг нэмэгдүүлэх хувилбарыг Засгийн газарт танилцуулна.	Хүүхдийн хоолны зардлын нормативыг нэмэгдүүлэх хувилбар, танилцуулга	Засгийн газрын 2019 оны 450, 2021 оны 207 дугаар тогтоол, 2022 оны 36, 55 дугаар тэмдэглэл, 2022 оны 498 дугаар тогтоол	Хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх, зардлын эцэг эх, асран хамгаалагч хариуцах хувь хэмжээний судалгаа, тооцооллыг боловсруулсан байна.	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоолны зардлын нормативыг нэмэгдүүлэх, төр болон эцэг эх хамтран хариуцах хувь хэмжээний хувилбарыг /төр 100%, төр эцэг эх 50/50 хувиар, 70/30 хувиар хариуцах/ боловсруулж, удирдлагуудад танилцуулсан. Хүүхдийн хоолны зардлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэх тооцооллыг боловсруулж, танилцуулсан. Улсын хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд 274,236 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж, үүнээс төрийн өмчийн цэцэрлэгт 242,109 хүүхэд суралцаж байна. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг Засгийн	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	---	--	---	--	--	---	--

					газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 төгрөг, 24 цагийн ажиллагаатай, сувилал, асрамжийн болон тусгай цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 3600 төгрөгөөр тогтоосныг мөрдөж байгаа бөгөөд цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд боломжит эх үүсвэрээс санхүүжүүлэхээр “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 2024.09.01-ний өдрөөс эхлэн 525 төгрөгөөр нэмэгдүүлэн 3000 төгрөг, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг, цэцэрлэгийн бүлгийн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 500		
--	--	--	--	--	---	--	--

					төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэхэд 11.8 тэрбум төгрөг шаардагдах тооцоотой байна. Хоолны зардлыг 500 төгрөгөөр нэмэгдүүлснээр хоол, хүнсээр авах шаардлагатай илчлэгийн 60.4 хувийг хангах боломжтой болно. Тогтоолын төсөлд яамдаас санал авч, саналыг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т албан бичгээр хүргүүлсэн. Тогтоолын төслийг Засгийн газрын 2024.05.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, уг тогтоолыг батлахаар дэмжигдсэн. Хавсралт: 5 файл		
4	Хүүхдийн хоол үйлдвэрлэл, хүнсний хангамжид үйлдвэрийн аргаар бэлтгэсэн хүнс, хоолны бэлдэц нийлүүлсэн аж ахуйн нэгж,	Эрх зүйн бичиг баримтын санал, төсөл	-	Судалгаа тооцооллыг боловсруулж, үр дагаврын шинжилгээг хийсэн байна.	Хүүхдийн хоол хүнсний хангамжийг сайжруулах, үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсийг сургууль, цэцэрлэгт нийлүүлэх, ерөнхий гэрээгээр худалдан авах зорилгоор БЕГ-аас	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн

	байгууллагыг татвар, урамшууллын бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх санал боловсруулах				боловсруулсан 23 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний техникийн шаардлагад санал өгсөн. 2024 оны 5 сарын байдлаар цахим дэлгүүрт 8 аж ахуйн нэгжээс 31 нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг нийлүүлж, давхардсан тоогоор 396 сургууль бүтээгдэхүүн захиалж худалдан авалт хийсэн байна. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хэрэгцээний судалгааг “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д заасан Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүс, Улаанбаатар хотоор ангилан хүнсний 6 бүлгээр, бүс тус бүрээр боловсрууллаа. Тухайлбал, махны хувьд улсын хэмжээнд хоногт 70 тонн, нэг сард 1,529 тонн, нэг хичээлийн жилд 12,6 мянган тонн шаардагдах тооцоотой байна. ЖАЙКА олон	сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
--	--	--	--	--	---	-------------------------	---

					улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хийсэн “Бага ангийн сурагчдын хоол тэжээлийн байдал”-д хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдсан сурагчдын 74% нь ясны сийрэгжилттэй, 26% нь зөөлөн эдийн зөөлрөлтэй, сурагчдын өдөрт хэрэглэж байгаа сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ нь авах шаардлагатай зөвлөмж хэмжээнээс 3.4 дахин бага дүнтэй гарсан. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдэд өдөрт 1 аяга сүү уулгаснаар кальци, Д амин дэмийн дутлыг нөхөх, ясны сийрэгжилтийг бууруулах, дархлааг сайжруулж, өсөлт хөгжлийг дэмжих бөгөөд зарим аймаг, орон нутгийн удирдлага, эцэг эхийн оролцоо дэмжлэгээр “Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Дээрх арга хэмжээг улсын хэмжээнд өргөжүүлэх хэрэгцээний судалгаа тооцооллыг боловсруулсан. Мөн	
--	--	--	--	--	---	--

					Хүнсний тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнс нийлүүлсэн аж ахуйн нэгжийг татвар, урамшууллын бодлогоор дэмжих, дэмжлэг үзүүлэх саналыг хүргүүлсэн. Хавсралт: 2 файл		
5	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хүнс, хоолны бэлдэц нийлүүлэх ажлыг хэрэгжүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангана.	ЕБС, цэцэрлэгт хүнс, хоолны бэлдэц нийлүүлж буй Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын тоо	Холбогдох судалгаа, тооцоолол	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагаас хүнс, хоолны бэлдэц нийлүүлэх чиглэлээр БЕГ-тай хамтран ажиллаж, бэлтгэл ажлыг хангуулна. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын 5-аас доошгүй байгууллагаас ЕБС, цэцэрлэгт хүнс, хоолны бэлдэц нийлүүлсэн байна.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хүнс, хоолны бэлдэц нийлүүлэх арга хэмжээний хүрээнд Дундговь, Завхан, Өвөрхангай, Ховд аймгийн ПК, Төв аймгийн Эрдэнэ сумын МСҮТ-ийг эхний ээлжинд сонгон хэрэгжүүлэхээр хүнс, хоол үйлдвэрлэлийн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. Дээрх сургуулиудаас Төв аймгийн Эрдэнэ сумын МСҮТ-ээс Баяндэлгэр, Эрдэнэ сум, аймгийн төвийн 5	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					сургуульд хөлдөөсөн бууз, банш, бөөрөнхий мах, сүү, тараг, боорцог, хэрчсэн гурилыг нийлүүлж байна. ПК, МСҮТ-д нийлүүлсэн тоног төхөөрөмжийн нөхцөл байдлыг газар дээр нь үзэх, бэлтгэл ажлын явцын байдалтай танилцах зорилгоор Дундговь аймгийн ПК-д газар дээр нь очиж ажиллахад нийлүүлсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл дутуу, гэрээний дагуу угсралт, суурилуулалт, заавар өгөөгүй зэрэг дутагдал илэрсэн бөгөөд бусад сургуулиас дээрхтэй адил нөхцөл илэрсэн тул холбогдох арга хэмжээг авч, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар Хөрөнгө оруулалтын хэлтэстэй хамтран БЕГ-т албан бичиг хүргүүлсэн. Уг арга хэмжээний бэлтгэл, хэрэгжилтийг хангуулах, холбогдох арга хэмжээ авч ажиллах тушаал, зааврын төслийг боловсруулж байна.			
6	Хүүхдийн хүнсний	хоол, чанар	Цахим хяналтын систем	Боловсролын мэдээллийн	Нийт сургуулийн 15 хүртэлх хувьд цахим	Боловсролын удирдлагын нэгдсэн	2-р сар, 3-р сар, 4-р	Өөрийн

	хүртээмж, аюулгүй байдалд цахим хяналтын системийг нэвтрүүлнэ.	нэврүүлсэн сургууль, цэцэрлэгийн тоо	санд үүсгэсэн систем	хяналтын системийг хэрэгжүүлсэн байна.	цахим систем дэх Хоолны системийг сайжруулах, хувийн хэвшлийн хөгжүүлж буй системийг холбох, мэдээлэл солилцох ажлыг эрчимжүүлэх чиглэлээр Цахим бодлого, статистик мэдээллийн газар, Боловсролын мэдээлэл, технологийн төв, сургууль цэцэрлэгүүдэд хоолны системийг хэрэгжүүлж буй 3 аж ахуйн нэгжийг оролцуулсан уулзалтыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд Боловсролын удирдлагын нэгдсэн цахим систем дэх Хоолны системд байршсан 4000 гаруй хоолны нэр төрлийг ангилан төрөлжүүлэх саналыг боловсруулж, хүргүүллээ. Үүнд: - Хоолны үндсэн ангилал модуль /1 болон 2-р хоол, салат/зууш, жимс, уух зүйлс, талх, нарийн боов гэсэн 5 ангилал/ - Дэд ангиллын модуль Дээрх үндсэн болон дэд ангиллын дагуу хоолыг бүлэглэн ангилж, системд тусгуулахаар БМТТ-д хүргүүлсэн. Мөн	сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
--	--	--------------------------------------	----------------------	--	---	--	---

					Боловсролын удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн боловсролын байгууллагын авах мэдээллийг боловсруулж хүргүүлээд байгаа бөгөөд уг системийг сайжруулснаар төрийн болон хувийн хэвшлийн дата мэдээллийг нэг загвараар боловсруулах, оруулах, хянах тогтолцоо сайжрах юм. Нийслэлийн 165 сургуулийн 20 буюу 12 хувь нь цахим хяналтын системийг хэрэгжүүлсэн байна.		
7	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журмыг батлуулна.	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журам	-	Журмыг батлуулсан байна.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь заалтыг үндэслэн "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам"-ыг эцэслэн боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс,	3-р сар, 4-р сар, 5-р сар	Өөрийн үнэлгээ: 30% Нэгжийн даргын үнэлгээ: 30% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/178, А/238, А/173 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан. Батлагдсан журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлж, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дээрх журмыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сангийн 6836 дугаарт бүртгэсэн тухай 2024.05.24-ний өдрийн 1/2740 дугаартай хариу албан бичгийг ирүүлсэн. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журмын төслийг боловсруулж байна.		
3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн гүйцэтгэлийг төлөвлөх, тайлагнах							
8	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн	Гүйцэтгэлийн хувь	-	Хууль, тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллага, нэгж, албан тушаалтанд хүргүүлэх				биелэлтийг Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд цаг тухай бүр оруулж тайлагнасан. Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулсан "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэгч байгууллагуудын 3 дахь удаагийн зөвлөлдөх уулзалтын хүрээнд зохион байгуулсан 6 чиглэлийн салбар хэлэлцүүлэгт оролцож, сургалтын байгууллагын хүүхдийн хоол хүнсний хангамжийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, тогтоолын хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэгт оролцсон. Хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг бэлтгэн ХШҮГ, удирдлагад хүргүүлсэн.	сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
9	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд	Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, архивын нэгж	-	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан архивын баримт бүрдүүлж хүлээлгэн өгсөн байна. Иргэд ,	Тайлангийн хугацаанд төрийн байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 29 албан бичиг, Засгийн газрын 11-11 төвөөр уламжлан 2 иргэнээс	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх			байгууллагаас ирүүлсэн албан бичгийг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна.	ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэж, 26 албан бичиг боловсруулж, холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгжид хүргүүлэн ажилласан. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан архивын баримт бүрдүүлж хүлээлгэн өгсөн.	сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	---	---

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг судлах	Эрхлэх асуудалд хамаарах шинээр батлагдсан хууль тогтоомжийг судлах, мэдээлэлийн сан	-	Судалсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр (тоогоор)	Эрхлэх асуудалд хамааралтай болон шинээр батлагдсан хууль, тогтоомж, дүрэм журам, тушаал шийдвэрийн цахим мэдээллийн санг бүрдүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

		бүрдүүлнэ.			Холбогдох хууль тогтоомжийг судалж, албан ажилдаа ашиглаж байна.	10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100%
2	Байгууллага болон мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах сургалт, мэдээллийн цагт бүрэн хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлнэ.	Байгууллага, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах дунд, богино хугацааны сургалтад танхимаар болон цахимаар хамрагдана.	-	Байгууллага, мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах дунд, богино хугацааны сургалтад танхимаар болон цахимаар хамрагдана.	Байгууллагаас зохион байгуулсан 4 удаагийн мэдээллийн цагт хамрагдаж, мэдээлэл авсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" сэдэвт цахим сургалтад хамрагдсан. Мөн Хүний эрхийн үндэсний комиссын 2023 оны тайлан болон Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн 2023 онд боловсролын сургалтын байгууллагад хийсэн хяналт шалгалтын тайлан, ЖАЙКА төслийн хүрээнд хийсэн хүүхдийн хоол шим тэжээлийн байдалд хийсэн судалгааны тайланг хүлээн авч танилцсан. Боловсрол, шинжлэх ухааны яам, БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх" төслийн хүрээнд зохион байгуулсан "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний сургагч багш" бэлтгэх 6 өдрийн 30 цагийн сургалтад	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					хамрагдсан.		
--	--	--	--	--	-------------	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогын удирдлага, зохицуулалт, тайлагналт, шим тэжээлийн асуудал хариуцсан шинжээч, Даваасүрэн Цэндсүрэн /...../ Огноо: